Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт
Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

~~2020~~ 2021 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

~~1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршино.~~

**1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, хамгаалах, үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах, хамтран ажиллах, Хүний эрх хамгаалагчийн хорооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.**

### 2 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын хууль тогтоомж

2.1.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль,[1] **Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль[2],** энэ хууль~~,~~ **болон** эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Монгол Улсын ~~нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа~~ **нутаг дэвсгэрт хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулсан, явуулж байгаа** хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлыг энэ хуулиар ~~тодорхойлно~~ **зохицуулна.**

**3.2.Гадаад улсын нутаг дэвсгэрт хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэний эрх зүйн байдлыг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зохицуулна.**

### ~~4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт~~

[1] Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн
[2] Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

~~4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:~~

~~4.1.1.“хүний эрх хамгаалагч” гэж ганцаараа, эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэхийг хөхиүлэн дэмжиж, хүчирхийллийн бус арга замаар хүний эрхэм чанар, олон улсын эрх зүйн нийтээр зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг хүндэтгэж, хамгаалахад оролцож байгаа хүнийг;~~

~~4.1.2.“хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх” гэж төрийн байгууллага, ашгийн бус хуулийн этгээд, аж ахуйн нэгжээс энэ хуулийн 4.1.1-т заасан этгээдийн хууль ёсны үйлдлийг таслан зогсоохгүй, саад учруулахгүй, эсхүл эрх, эрх чөлөөнд нь хууль бусаар халдахгүй байх үүргийг;~~

~~4.1.3.“хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах” гэж төрийн болон төрийн бус этгээдийн зүгээс энэ хуулийн 4.1.1-т заасан этгээдийн Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд чиглэгдсэн төрийн байгууллагын үүргийг;~~

~~4.1.4."хүний эрх хамгаалагчийн эрхийг хангах” гэж энэ хуулийн 4.1.1-т заасан этгээдийн хууль ёсны үйлдлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохистой нөөцийг хуваарилж, үйл ажиллагааны баталгаа бүрдүүлэх төрийн үүргийг;~~

~~4.1.5."хүний эрх хамгаалагчийн эрхийг зөрчих” гэж Хүний эрх хамгаалагчийн хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаатай холбогдуулан түүнд болон түүний гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, хууль ёсны төлөөлөгчийг доромжлох, гүтгэх, хуурч мэхлэх, залилах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, эсхүл хүчирхийлэх, худал цуу тараах, үйл ажиллагааг нь дэмжихгүй байх, дэмжихгүй байхыг уриалах, албадах, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, мөрдөн мөшгих, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд нь гэм хор учруулах үйлдэл, эс үйлдэхүйг;~~

~~4.1.6.“гэр бүлийн гишүүн” гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан хүнийг;~~

~~4.1.7.“хамтран амьдрагч” гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.6-д заасан хүнийг;~~

~~4.1.8.“эрсдлийн үнэлгээ” гэж хүний эрх хамгаалагчид учирч буй аюул, эрсдлийн зэргийг тодорхойлох, цаашид хамгаалалтад авах шаардлагатай эсэхийг үнэлсэн дүгнэлтийг.~~

**<u>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</u>**

**<u>4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:</u>**

4.1.1.“хүний эрх хамгаалагч” гэж ганцаараа, эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа, түүнд оролцож байгаа хүнийг;

4.1.2.“хүний эрх хамгаалах үйл ажиллагаа” гэж хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн эсрэг хүчирхийллийн бус, тайван аргаар үзэл бодлоо илэрхийлж, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг хүндэтгэж, хүний эрхийг хамгаалах;

4.1.3.“хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах” гэж төр, хүн, хуулийн этгээд, тодорхой ашиг сонирхлоор нэгдсэн аливаа этгээдийн зүгээс хүний эрх хамгаалагчийн эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд чиглэгдсэн төрийн байгууллагын үүргийг;

4.1.4.“хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх” гэж төрийн байгууллага хүн, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн хууль ёсны үйлдлийг таслан зогсоохгүй, саад учруулахгүй, эсхүл эрх, эрх чөлөөнд нь хууль бусаар халдахгүй байх үүргийг;

4.1.5.“хүний эрх хамгаалагчийн эрхийг зөрчих” гэж хүний эрх хамгаалах үйл ажиллагаатай нь холбогдуулан хүний эрх хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамтран амьдрагч, төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгчийг аливаа хэлбэрээр доромжлох, гүтгэх, худал мэдээлэл тараах, ялгаварлан гадуурхах, үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах, албадах, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, мөрдөж мөшгих, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд нь гэм хор учруулах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.6.“эрсдэлийн үнэлгээ” гэж хүний эрх хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамтран амьдрагч, төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгчид учирч буй аюул, эрсдэлийн түвшнийг тодорхойлсон дүгнэлтийг.

~~**5 дугаар зүйл. Хуулийн үндсэн зарчим**~~

~~5.1.Хүний эрх хамгаалагч үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:~~

~~5.1.1.хүний эрхэм чанарыг хүндэтгэх;~~
~~5.1.2.хууль дээдлэх;~~
~~5.1.3.ялгаварлан гадуурхахгүй байх;~~
~~5.1.4.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;~~
~~5.1.4.хариуцлага зайлшгүй байх.~~

**5 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

**5.1.Хүний эрх хамгаалагч үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:**

**5.1.1.Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх;**
**5.1.2.шударга, хүнлэг ёсыг эрхэмлэх;**
**5.1.3.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;**
**5.1.4.ялгаварлан гадуурхахгүй байх;**
**5.1.5.бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.**

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙН ЭРХ, САНХҮҮЖИЛТ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ

### 6 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн эрх

6.1.~~Хүний эрх хамгаалагч Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаас гадна дараах эрхтэй байна.~~
**6.1.Хүний эрх хамгаалагч дараах бүрэн эрхтэй:**

6.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, ~~хамгаалахад~~ **хамгаалах үйл ажиллагаа явуулах, сайн дураар** оролцох;

6.1.2.хүний эрхийн талаарх шинэ ойлголт, зарчмыг боловсруулах, хэлэлцэх, ~~таниулах, тэдгээрийг~~ **олон нийтэд таниулах,** хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлөх;

6.1.3.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилгоор аливаа хэлбэрээр эвлэлдэн нэгдэх, төрийн бус байгууллага, эвсэл, холбоо, бүлэг, нэгдэл байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох;

~~6.1.4.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор тайван жагсаал, цуглаан санаачлах, зохион байгуулах, оролцох, мэдээллийг түгээх;~~

~~6.1.5.үндэсний, гадаад улсын, бүс нутгийн эсхүл олон улсын байгууллага, эвсэл, сүлжээтэй харилцах, хамтран ажиллах;~~
**6.1.4.хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулдаг үндэсний болон гадаад улсын, бүс нутгийн болон олон улсын байгууллагатай харилцах, хамтран ажиллах;**

~~6.1.6.хуулиар хориглосноос бусад арга замаар санхүүгийн нөөц, эх үүсвэрийг хайх, хүлээн авах, захиран зарцуулах;~~

~~6.1.7.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд шаардлагатай Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулиар төрийн болон бусад байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг төр, хувийн хэвшил, иргэний нийгмээс аливаа хэлбэрээр хүлээж авах, эрж хайх, олох, мэдэх, хэвлэн нийтлэх, хадгалах, бусадтай хуваалцах;~~

**6.1.5.хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад мэдээллийг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, хуулийн этгээдээс хуульд заасан аргаар хайх, олж авах, хэвлэн нийтлэх, хадгалах, бусадтай хуваалцах;**

~~6.1.8.~~6.1.6.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явцад олсон мэдээллийн эх сурвалжийг тухайн хүний эрхийн зөрчил арилж, эрх бүрэн сэргээгдэх хүртэл хугацаанд нууцлах;

~~6.1.9.~~6.1.7.хууль тогтоомжийн төслийг хүний эрхийн зарчимд нийцүүлэх зорилгоор олон нийтийн анхааралд хандуулах, тодорхой санал боловсруулах, ~~үүнийгээ хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлөх,~~ хэлэлцүүлэх, хууль тогтоогчид хүргүүлэх, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, шаардлагатай санал зөвлөмж боловсруулах;

~~6.1.10.~~6.1.8.~~төрийн үйл хэрэгт оролцох,~~ төрийн байгууллага, албан тушаалтныг хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хангах, хамгаалах чиг үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор ~~шүүмжлэх,~~ санал, хүсэлт тавих, гомдол гаргах, ~~зөвлөмж хүргүүлэх,~~ хүний эрхийн зөрчил, хууль бус үйлдэлд анхаарлыг нь хандуулах, энэ талаар бусдад мэдээлэх;

~~6.1.11.~~6.1.9.хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор тухайн этгээдийн **бичгээр гаргасан** зөвшөөрлөөр төлөөлөх;

~~6.1.12.~~6.1.10.төрийн байгууллага, албан тушаалтан, ~~төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн~~ **хуулийн этгээдийн** удирдлагын зүгээс өөрийн болон бусдын эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдлийн талаар **холбогдох олон улсын гэрээнд заасан журмын дагуу** олон улсын хүний эрхийн байгууллагад хандан гомдол гаргах;

~~6.1.13.~~6.1.11.хуульд өөрөөр заагаагүй бол шүүх хуралдаан, ~~хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа,~~ нийтийн сонсголд ~~ажиглалт хийх,~~ **ажиглагчаар оролцох,** төрийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомж болон ~~олон улсын холбогдох хэм хэмжээг~~ **Монгол Улсын олон улсын гэрээг** дагаж мөрдөж байгаа эсэхэд байр сууриа илэрхийлэх;

~~6.1.14.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар аливаа хүнд өөрийнх нь хүсэлтээр зөвлөгөө өгөх, бусад туслалцаа үзүүлэх, санал болгох;~~

~~6.1.15.Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг албадан гаргах тохиолдолд тухайн этгээдийн хүсэлтээр уулзах, зөвлөгөө өгөх, туслах;~~

~~6.1.16.өөрт нь эсхүл гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, төрлийн буюу садангийн хүн эрсдэлд өртсөн, өртөх нөхцөл бодитой бүрэлдсэн тохиолдолд гэрч, хохирогч, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн этгээдтэй дүйцэхүйц хамгаалалт хүсэх;~~

~~6.1.17.~~6.1.12.хүний эрх хамгаалагчийн хувиар явуулсан үйл ажиллагааныхаа үед халдлагаас хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, ~~сэтгэл~~

~~санааны болон бодит хохирлоо~~ **эдийн болон эдийн бус хохирлоо хуульд заасан журмын дагуу** барагдуулах, нөхөн төлбөр авах;

~~6.1.18.цахим мэдээллийг нууцалсан хэлбэрээр солилцох боломжтой байх, цахим мэдээллийн нууцлалд хууль бусаар халдахаас хамгаалуулах;~~

**7 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны санхүүгийн ил тод нээлттэй байдал.**

**7.1.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон аливаа санхүүгийн нөөц, эх үүсвэр ил тод, нээлттэй байх бөгөөд санхүүгийн нөөц дараах эх үүсвэрээс бүрдэнэ:**

**7.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол хүн, хуулийн этгээдээс өгсөн хандив, тусламж;**

**7.1.2.хуульд заасны дагуу төрөөс үзүүлсэн мөнгөн болон бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг;**

**7.1.3.хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.**

**7.2.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны санхүүжилтэд дараах нөөц, эх үүсвэрийг хориглоно:**

**7.2.1.Гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдлийг бусниулах, мөнгө угаах, террорист болон экстремист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжүүлдэг байгууллага, хувь хүнээс, эсхүл хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт авахыг хориглоно.**

**7.2.2.хуулиар зөвшөөрснөөс бусад аргаар санхүүгийн нөөц, эх үүсвэрийг хайх, хүлээн авах, захиран зарцуулахыг хориглоно.**

**~~7 дугаар зүйл.~~8 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчид хориглох зүйл**

~~7.1.~~8.1.Хүний эрх хамгаалагчид дараах үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно:

~~7.1.1.~~8.1.1.хүчирхийллийн арга **хэрэглэж**, тайван бус ~~замаар~~ **аргаар** үйл ажиллагаа явуулах, явуулахыг уриалах;

~~7.1.2.~~8.1.2.хүний эрх хамгаалагчийн ~~алдар хүнд, нэр төрийг~~ **үйл ажиллагааг** хувийн ашиг сонирхолд ашиглах;

~~7.1.3.~~ 8.1.3.хүний эрх, эрх чөлөөг үл хүндэтгэх, зөрчих.

**~~ГУРАВДУГААР БҮЛЭГ~~**

**~~ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН ХҮЛЭЭХ НИЙТЛЭГ ҮҮРЭГ~~**

**8 дугаар зүйл. Нийтлэг үүрэг**

8.1.Төрийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж дараахь нийтлэг үүргийг хүлээнэ:

8.1.1.хүний эрх хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, зөрчихгүй байх, үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах, хүний эрх хамгаалагч хүчирхийллийн бус, тайван замаар дарамт шахалт, сүрдүүлэг, аливаа айдаст авталгүйгээр үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах;

8.1.2.хуульд заасан үндэслэлгүйгээр хүний эрх хамгаалагчид аливаа хэлбэрээр халдахгүй байх;

8.1.3.хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг байгууллагын дотоод журамдаа тусгаж, хэрэгжүүлэх, ажилтнуудад сургалт зохион байгуулах;

8.1.4.хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа явуулж буй хүний эрх хамгаалагчид шаардлагатай газар, мэдээллийн эх сурвалжид чөлөөтэй нэвтрэх боломж олгох;

8.1.5.хүний эрх хамгаалагчид халдсан тухай мэдээлэл, гомдлыг шийдвэрлэсэн хариуг бичгээр Хүний эрх хамгаалагчийн хороонд хүргүүлэх.

**9 дүгээр зүйл. Төрийн байгууллага, албан тушаалтны чиг үүрэг**

9.1.Монгол Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.хүний эрх хамгаалагчийн талаарх бодлого боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

9.1.2.хүний эрх хамгаалагчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгоход шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох санд хуваарилах;

9.2.Хүний эрх хамгаалагчийн талаар эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.2.1.цагдаагийн байгууллага хүний эрх хамгаалагчид халдсан халдлагыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу таслан зогсоох, өөрийнх нь зөвшөөрснөөр хамгаалалтад авах, эсхүл энэ хуулийн 11.7-д заасан Хүний эрх хамгаалагчийг хамгаалах хорооны эрсдлийн үнэлгээний дүгнэлтийг үндэслэн хүний эрх хамгаалагчийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалалтад авах;

9.2.3.төрийн эрх бүхий байгууллага хүний эрхийг хамгаалах үйлдэлтэй нь

~~холбогдуулан мөрдөн шалгах ажиллагаа явуулах тохиолдолд Хүний эрх хамгаалагчийн хороонд нэн даруй мэдэгдэх;~~

~~9.2.4.хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хуулиар хариуцсан чиг үүргийн хүрээнд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах.~~

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**
## **ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НИЙТЛЭГ ҮҮРЭГ**

**9 дүгээр зүйл.Нийтлэг үүрэг**

**9.1.Төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд дараах нийтлэг үүргийг хүлээнэ:**

**9.1.1.хүний эрх хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, зөрчихгүй байх;**

**9.1.2.үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах;**
**9.1.3.хүчирхийллийн бус, тайван аргаар үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх;**

**9.1.4.шаардлагатай мэдээллээр хангах;**
**9.1.5.хуульд заасан үндэслэлгүйгээр хүний эрх хамгаалагчид аливаа хэлбэрээр халдахгүй байх;**

**9.1.6.хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусгаж, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах;**

**9.1.7.хүний эрх хамгаалагчид халдсан тухай мэдээлэл, гомдлыг шийдвэрлэсэн хариуг бичгээр гомдол гаргагчид болон Хүний эрх хамгаалагчийн хороонд хүргүүлэх.**

**9.2.Цагдаагийн байгууллага хүний эрх хамгаалагчид халдсан халдлагыг таслан зогсоох, түүнийг өөрийнх нь зөвшөөрснөөр эсхүл энэ хуулийн 11.8-д заасан эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд[3] заасан журмын дагуу хамгаалалтад авна.**

**9.3.Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хуулиар хариуцсан чиг үүргийн хүрээнд шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.**

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО

[3] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2013 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

~~**10 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн хороо**~~

~~10.1.Хүний эрх хамгаалагчийн хороо (цаашид "Хороо" гэх) нь төр, олон нийтийн төлөөлөл бүхий хүний эрх хамгаалагчийг хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байна. Хороо нь хүний эрх хамгаалагчид халдсан тухай мэдээлэл, гомдлын дагуу холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх, бичгээр хариу авах; эрсдлийн үнэлгээ хийх, хүний эрх хамгаалагчийг хамгаалах шаардлагыг үнэлж дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.~~

~~10.2.Хороо нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд бие даасан, хараат бус байдлаар, иргэний нийгэм, ялгаварлан гадуурхалтад өртсөн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллана.~~

~~10.3.Хороо ашгийн бус хуулийн этгээдээс нэр дэвшин сонгогдсон дөрвөн гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч, Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч гэсэн 7 хүний бүрэлдэхүүнтэй байна.~~

~~10.4.Хорооны дарга нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн байна.~~

~~10.5.Хорооны бүрэлдэхүүнийг томилоход жендэрийн тэнцвэртэй байдал, үндэсний хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хүний эрх хамгаалагчдын олон талт төлөөллийг хангана.~~

~~10.6.Хорооны дарга, гишүүд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.~~

~~10.7.Хорооны дарга, гишүүд улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэнэ.~~

~~10.8.Хорооны үйл ажиллагааны санхүүжилтийг Комиссын төсөвт тусгана.~~

**10 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн хороо**

**10.1.Хүний эрхийн Үндэсний Комиссын /цаашид "Комисс" гэх/ дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо (цаашид "Хороо" гэх) ажиллана.**

**10.2.Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн Хорооны дарга байх бөгөөд Хорооны үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллана.**

**10.3.Хороо үйл ажиллагаагаа бие даан явуулах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

**10.3.1.хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах;**

10.3.2.гомдол мэдээллийн талаар нотолгоо, баримт, мэдээлэл цуглуулах;

10.3.3.хүний эрх хамгаалагчийг хамгаалах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, энэ хуулийн 11.8-д заасан эрсдэлийн үнэлгээ хийх;

10.3.4.эрсдэлийн үнэлгээнд үндэслэн гаргасан дүгнэлтийг Комиссд хүргүүлэх;

10.3.5.энэ хуулийн хэрэгжилт болон хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдалд хяналт шинжилгээ, судалгаа хийж, жил бүр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд тусгуулах;

10.3.6.гомдол, мэдээллийн сан бүрдүүлэх.

10.4.Хороо нь энэ хуулийн 10.2-т заасан даргаас гадна зургаан гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд энэ хуулийн 11.4-т заасан хоёр нэр дэвшигчийг шууд, бусад дөрвөн гишүүнийг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс нэр дэвшүүлэн, нээлттэй сонсголоор сонгон шалгаруулж, Комисс батламжилна.

10.5.Хорооны бүрэлдэхүүнийг томилохдоо жендэрийн тэнцвэртэй байдал болон үндэсний хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хүний эрх хамгаалагчийн олон талт төлөөллийг хангана.

10.6.Хорооны гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

10.7.Хорооны гишүүн улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэнэ.

10.8.Хорооны үйл ажиллагааны урсгал зардлыг Комиссын төсөвт тусгах бөгөөд Хорооны гишүүнд урамшуулал олгох журмыг Комисс батална.

10.9.Хорооны ажиллах журмыг Комисс батална.

**11 дүгээр зүйл.Хорооны гишүүнийг сонгох**

~~11.1.Ашгийн бус хуулийн этгээдийн төлөөллөөс Хорооны гишүүнд дараах шаардлагыг хангасан хүнийг нэр дэвшүүлнэ:~~

~~11.1.1.хүний эрхийг хамгаалах чиглэлээр идэвхитэй, тасралтгүй 7-оос доошгүй жил үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай;~~

~~11.1.2.олон улсын, үндэсний хэмжээний хүний эрхийн сүлжээнд ажилладаг;~~

~~11.1.3.Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороод, Хүний эрхийн~~

~~зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг зэрэг олон улсын механизмд хөндлөнгийн хараат бус илтгэл бичсэн;~~

~~11.1.4. ёс зүйтэй байх.~~

**11.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс Хорооны гишүүнд дараах шаардлагыг хангасан хүнийг нэр дэвшүүлнэ:**

**11.1.1.хүний эрхийг хамгаалах чиглэлээр үндэсний, эсхүл олон улсын хэмжээнд долоогоос доошгүй жил ажилласан туршлагатай;**

**11.1.2.хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо, эрх зүйн хэм, хэмжээний талаар мэдлэг, туршлагатай;**

**11.1.3.сүүлийн таван жил улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй.**

~~11.2.Ашгийн бус хуулийн этгээдийн төлөөллөөс нэр дэвшүүлэх Хорооны 4 гишүүнийг дараах журмаар сонгоно:~~

~~11.2.1.Хүний эрхийн Үндэсний Комисс нээлттэй нэр дэвшүүлэх зарыг 6 сараас доошгүй хугацааны өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудсаар түгээнэ.~~

~~11.2.2.Хүний эрхийн Үндэсний Комисс, тус Комиссын Иргэний нийгмийн зөвлөлийн, ашгийн бус хуулийн этгээдийн төлөөлөл бүхий ажлын хэсэг /цаашид ажлын хэсэг гэх/ нээлттэй зар түгээснээс хойш 6 сарын дараа нэр дэвшигчдийн жагсаалтыг нэгтгэн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албаны цахим хуудсаар танилцуулна.~~

~~11.2.3.ажлын хэсэг энэ хуулийн 11.1-д заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчдийг оролцуулсан нээлттэй сонсгол хийж, нэр дэвшигчдийн талаар хэлэлцүүлэг явуулна.~~

~~11.2.4.нээлттэй сонсголын дараа ажлын хэсэг шалгаруулалт хийж, шаардлага хангасан нэр дэвшигчдийн материалыг шалгаруулсан талаарх тэмдэглэлийн хамт Хүний эрхийн Үндэсний Комиссын Иргэний нийгмийн зөвлөлд хүргүүлнэ.~~

~~11.2.5.Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүд саналаа нууцаар гаргаж, хамгийн олон санал авсан 4 нэр дэвшигчийг Хорооны гишүүнээр сонгогдсонд тооцно.~~

**11.2.Хорооны гишүүнийг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс дараах үе шатаар сонгоно:**

**11.2.1.Комисс нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Комисс, Төрийн албаны зөвлөл, Жендэрийн үндэсний хороо, Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн таван**

**хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;**

**11.2.2.ажлын хэсэг Хорооны гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 30 хоногийн хугацаанд нийтэд мэдээлэх;**

**11.2.3.ажлын хэсэг энэ хуулийн 11.2.2-т заасан хугацаа дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн нэр дэвшигчийн хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг Комиссын цахим хуудаст байршуулах;**

**11.2.4.ажлын хэсэг энэ хуулийн 11.2.3-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах;**

**11.2.5.ажлын хэсэг энэ хуулийн 11.1-т заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчийн талаар нээлттэй сонсгол зохион байгуулах;**

**11.2.6.ажлын хэсэг нээлттэй сонсгол зохион байгуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор нууц санал хураалт явуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчээс сул орон тоо гарсан гишүүний тоогоор Хорооны гишүүнээр сонгох.**

**11.3.Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Комисс батална.**

~~11.3.~~11.4.~~Хүний эрхийн Үндэсний Комисс,~~ Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо нь тус тусын хуралдаанаараа нэр дэвшигчээ шалгаруулж Хүний эрхийн Үндэсний Комиссын хуралдаанд санал болгоно.

~~11.4.~~11.5.Энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, ~~11.3-т~~ **11.4-т** заасан журмаар сонгогдсон ~~хүнийг~~ **этгээдийг** ~~Хүний эрхийн Үндэсний~~ Комиссын хуралдаанаар ~~Хүний эрх хамгаалагчийг хамгаалах хорооны~~ **Хорооны** гишүүнээр батламжилна.

~~11.5.Хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жил байх ба нэг удаа улируулан сонгож болно.~~

**11.6.Хорооны гишүүнийг гурван жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.**

~~11.6.~~11.7.Хорооны гишүүнийг дараах үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлөх асуудлыг Хорооны хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

~~11.6.1.~~11.7.1.төрийн улс төрийн, **төрийн** захиргааны, **төрийн** тусгай албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон;

~~11.6.2.~~11.7.2.биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар Хорооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боломжгүй болсон тухай өөрөө хүсэлт гаргасан;

~~11.6.3.~~11.7.3.~~гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон.~~ **гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.**

~~11.7.~~11.8.Энэ хуулийн ~~4.1.8-д~~ **4.1.6-д** заасан эрсдлийн үнэлгээ хийх аргачлал, дүгнэлт гаргах журмыг ~~Хороо боловсруулж, Хүний эрхийн Үндэсний Комиссоос баталж, мөрдүүлнэ.~~**Комисс батална.**

**12 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн хорооны нэгж**

**12.1.Хорооны гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллах бөгөөд бүтэц, орон тоог Комисс батална.**

**12.2.Хорооны нэгжийн ажилтан төрийн захиргааны албан хаагч байна.**

**12.3.Хорооны нэгж нь Комиссын Тамгын газарт харьяалагдах бөгөөд зөвхөн энэ хуулийн 10.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.**

~~**12 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**~~

~~12.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, албан тушаалтан, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан зохих хариуцлага хүлээлгэнэ.~~

~~12.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.~~

**13 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

**13.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд[4] заасан хариуцлага хүлээлгэнэ.**

**13.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль[5], эсхүл Зөрчлийн тухай хуульд[6] заасан хариуцлага хүлээлгэнэ."**

**~~13 дугаар зүйл.~~ 14 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

13.1.Энэ хуулийг 2020 оны ....... сарын ... –ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

---

[4] Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.
[5] Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
[6] Зөрчлийн тухай "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт
Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

~~2020~~ 2021 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**.Гэрч хохирогчийг хамгаалах тухай ~~хуульд~~ **хуулийн 4 дүгээр зүйлд** доор дурдсан агуулгатай ~~дараах хэсэг~~, **4.1.4 дэх** заалт нэмсүгэй:

**4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт:**

"4.1.4."хүний эрх хамгаалагч" гэж Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.1-т заасныг."

**2 дугаар зүйл.**Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.3~~, 5.4 дэх~~ **дахь** хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/"5.1.Энэ хуулийн зохицуулалтад гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагч хамаарна:

2/"5.2.Шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагчийн хамаарал бүхий этгээдийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж болно.:

3/"5.3.Энэ хуулийн 5.2-т заасан гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагчийн хамаарал бүхий этгээд гэж тэдгээрийн нөхөр /эхнэр/, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охиныг ойлгоно.:

**3 дугаар зүйл.**Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр ~~зүйлийн 21.2 дахь хэсэгт дараахь~~ **зүйлд доор дурдсан агуулгатай 21.2.4 дэх** заалтыг нэмсүгэй;

21.2.4.Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах асуудлаар Хүний эрх хамгаалагчдын хорооны хүсэлтээр ~~мөрдөн байцаагч~~ **мөрдөгч;**

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт
Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

~~2020~~ 2021 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ~~, ӨӨРЧЛӨЛТ~~ ОРУУЛАХ ТУХАЙ

~~**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 6.23 дахь зүйл нэмсүгэй:~~

~~**"1/6.23 дугаар зүйл Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих**~~

~~1.Хуулийн 6 дугаар зүйлд заасныг зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.~~

~~2.Хуулийн 7 дугаар зүйлд заасныг зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.~~

~~3.Хуулийн 11.7 дугаар зүйлд заасныг зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно."~~

**1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 5.20 дугаар зүйл нэмсүгэй:**

**"5.20 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих:**

**1.Хүний эрх хамгаалагчийг доромжлох, гүтгэх, үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах, албадах арга хэрэглэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.**

**2.Хүний эрх хамгаалагч нь хүчирхийллийн арга хэрэглэж, тайван бус аргаар үйл ажиллагаа явуулсан, явуулахыг уриалсан, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашигласан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно."**

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг